

Ж.ЦЭВЭЭНИЙ ХАМТРАН ЗУТГЭГЧДИЙН НИЙТЛЭЛ,  
ҮЙЛ АЖИЛЛАГАА

Т. Баасансүрэн\*

\* «Улаанбаатар Эрдэм» Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

**Түлхүүр үг:** Ж.Цэвээн, үндэсний ууган хэвлэл, “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг”, найруулал

**И**х соён гэгээрүүлэгч Жамсраны Цэвээн тэргүүтэй Монголын үндэсний дэвшилт сэхээтнүүд 1913 оны 3 дугаар сарын 6-нд “Шинэ толь хэмээх бичиг” сонины анхны дугаарыг нийслэл Хүрээнд хэвлэн гаргасан нь Монголын нийгмийн амьдралд тохиолдсон онцгой содон тэмдэглэлт үйл явдал байлаа. 1913-1914 онд 20 дугаар гаргасан “Шинэ толь хэмээх бичиг” нь 1915-1920 онд “Нийслэл хүрээний сонин бичиг” нэрээр үргэлжлэн гарсан билээ.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, томоохон нийтлэл орчуулгыг Ж.Цэвээн өөрөө голлон гүйцэтгэж, шүүмжлэлт өгүүлэл, иргэний нийтлэлийг Д.Бодоо, Засгийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээ сонсгол, Автономитын дээд, доод хурал, ардчиллын сэдэвтэй найрууллуудыг Д.Бадрахбаатар, шуурхай мэдээ мэдээллийг Жанцансамбуу бичиж байсан тухай доктор Г.Дэлэг, Л.Норовсүрэн нар өөрсдийн судалгаанд тэмдэглэсэн байдаг.

Ямар ч хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний дотор тогтмол хэвлэл нь юуны өмнө хамтын бүтээл байдаг билээ. Тийм учраас “Шинэ толь хэмээх бичиг” ба “Нийслэл хүрээний сонин бичиг” сонины нийтлэлийг шинжлэн судалж үзэхдээ тухайн хэвлэлийг эрхлэн гаргахад гар бие, сэтгэл оюунаа харамгүй зориулж байсан анхдагч сэтгүүлчдээс хэн нь ямар үүрэг гүйцэтгэж байв, тэд ямар ямар нийтлэлийг бидэнд өвлүүлж үлдээв гэдэгт анхаарал хандуулах явдал маш чухал юм.

“Шинэ толь хэмээх бичиг” ба “Нийслэл хүрээний сонин бичиг” сонины эрхлэгч Ж.Цэвээн эдгээр сонины “бодлого, үзэл санаа, агуулгыг ардчилсан чиг баримжаатай болгосон” гэж түүхч Д.Дашжамц бичжээ<sup>1</sup>. Үүнтэй сэтгүүл зүйн нийт судлаач санал нэгдэнэ гэж бодож байна. XX зууны эхэн үеийн монголчуудын оюун санааны эцэг гэгддэг энэ хүн яах ч аргагүй “Шинэ толь хэмээх бичиг” ба “Нийслэл хүрээний сонин бичиг” сонины нийтлэлийн бодлого, чиглэлийг тодорхойлж байсан нь бодит үнэн юм.

Харин Догсомын Бодоо, хошой гүн Бадрахбаатар, Бунибазарын Дорж,

Жанцансамбуу нарын бусад нөхөд ямар үүрэгтэй сонины ажилд оролцож, юу юуг бичиж үлдээв гэдэг мэдээлэл өнөө хэр бүрэн гүйцэд судлагдаж хараахан чадаагүй байна.

Монголын үндэсний сэтгүүл зүйн 100 жилийн ойн өмнө “Монголын шилдэг нийтлэл” эрдэм шинжилгээ, судалгааны төвөөс эрхлэн гаргаж буй цуврал 99 ботийн эхний ботийг 2010 онд Жамсраны Цэвээний нийтлэл, тэмдэглэл, захидлаар (эрхлэн гаргагч нь Т.Баасансүрэн, Л.Норовсүрэн нар), Догсомын Бодоо, хошой гүн Бадрах-баатар, Бунибазарын Дорж нарын нийтлэл, өгүүлэл, бичиг захидлуудыг 2011 онд мөн цувралын хоёр дахь боть болгон (эрхлэн гаргагч нь Л.Норовсүрэн Т.Баасансүрэн нар) хэвлүүлж уншигчдын хүртээл болгосон нь дээрх чиглэлээр хийсэн анхны алхам болсон юм.

“Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 ботийн 2 дахид Догсомын Бодоогийн “Бүдүүлэг цагийн эсэргүүцлийн модон шийдмийг тас цавчих Болд-Илдийн эсэргүүцэл”, “Малаар баялаг болтугай”, “Зарим нэг жинстний явдал”, “Багахан өгүүлэл”, “Намын байгууллага захиргааны ажилд оролцохгүй нь дээр”, “Хэт хээнцэрлэхийг хэмжээлье” зэрэг 24 нийтлэл, өгүүлэл, тэрчлэн “Жалханз хутагтад илгээсэн захидал”, “ЗСБНХОУ-ын Засгийн газарт”, “Америкийн Нэгдсэн Улсын гадаад хэргийн сайдад”, “Дилэв хутагтад бичсэн захидал”, “Судар бичгийн хүрээлэн байгуулах тухай Богд хаанд өргөсөн бичиг” зэрэг 13 захидлыг багтаасан болно. Энэ нь түүний нийтлэлүүдийг боломжийн хэрээр олж цуглуулж нэгтгэх гэсэн бидний оролдлогын нэг илрэл бөгөөд өмнө нь 2001 онд доктор

түүхч Л.Бат-Очир Д.Бодоотой холбоотой 90 гаруй түүхэн баримт бичгийг нэгтгэж байжээ. Мөн сүүлд доктор Ч.Билэгсайхан түүний зарим бүтээлийг эмхэтгэж гаргасан байна. Эдгээр ном зохиол нь зохиолч, сэтгүүлч Догсомын Бодоогийн үйл амьдрал, ялангуяа түүний нийтлэлүүдийг гүнзгийрүүлэн судлахад тус нэмэр болох нь гарцаагүй юм. Сүүлийн жилүүдэд Монголын нэрд гарсан түүхчид Монгол Ардын Намыг үүсгэн байгуулалцах хийгээд 1921 оны Ардын хувьсгалын үйл хэрэгт идэвхтэй оролцогч, Монгол Улсын анхны ерөнхий сайдаар томилогдон ажиллаж байсан Догсомын Бодоогийн хувьсгалт үйл ажиллагаанд үнэн бодит үнэлэлт дүгнэлт өгч, өмнөх түүхийн гажуудлыг арилган залруулж байгаа, түүний төрсөн нутаг Төв аймгийн төвд цээж хөшөө баримлыг нь босгосон зэрэг нь үнэхээр сайшаалтай хэрэг юм.

**С**этгүүл зүй, утга зохиолын судлаачдын хувьд Д.Бодоогийн зохиол бүтээл, нийтлэлүүдийг нарийвчлан судлах, тухайлбал Монголд тогтмол хэвлэлийг үүсгэн буй болгоход түүний оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүргийг товойлгон гаргах явдал нэн чухлаар шаардагдаж байгаа болно. Доктор, профессор Л.Норовсүрэн «Д.Бодоо “Шинэ толь хэмээх бичиг”-ийн дотоодын эдийн засаг, аж ахуй, сургууль соёлын сэдэвтэй шүмжлэлт өгүүлэл, иргэний нийтлэлийг хариуцан бичдэг байсны дээр Ж.Цэвээнтэй хамтран “Хоршооны дүрэм” боловсруулж улсын дээд, доод хуралд оруулж байжээ. Тэрбээр “Нийслэл хүрээний сонин бичиг”-т хурц шүмжлэлт нийтлэлээ “Болд-Илд” гэдэг нууц нэрээр бичдэг байв. Түүнээс гадна “Шинэ толь хэмээх бичиг”-т хоёр ч удаа

тааралдаж байгаа "Монголын есөн хуруут" гэдэг нууц нэр Д.Бодоогийнх баймаар санагдана<sup>2</sup> гэжээ. Энэ мэт Д.Бодоотой холбоотой цааш нь тодруулж гүнзгийрүүлэн судалбал зохих цөөнгүй зүйлс байгаа юм.

"Бидний ардын төлөөлөгчдөөс Богд хаан болон олон лам ноёд та бүхний сануулсан ёсоор Их Орос Улсын тусламжийг олж гадаадын харгисыг сөнөөж, газар орноо бүрэн бүтэн болгож авав... Богд эзнийг хэмжээтэй эзэрхэх хаанд өргөмжлөн, ардын эрхт засгийг нэгтгэж байгуулах болно"<sup>3</sup> гэж кино дэлгэцнээс Богд хаанд бараалхах үеэр түүний хэлж байгаа гал цогтой үгээр нь Монголын ард түмэн Догсомын Бодоог мэддэг ч түүний зохиолч, сэтгүүлчийн үйл ажиллагааг нь төдийлөн сайн мэддэггүй хэвээр байгаа билээ.

**М**онголын анхны сонинуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцогчийн нэг нь Бунибазарын Дорж юм. Бид түүний бичиж туурвисан "Бичгийн өртөө байгуулах нь", "Шинэ хуучин хэмжүүрийн тухай", "Үстэй дээлийн илч үү?", "Тунг долоосон би үхмөй", "Чоно их л хартай амьтан бөгөөтөл бухын арганд унасан нь" зэрэг арваад нийтлэлийг нь "Монголын шилдэг нийтлэл" цуврал 99 ботийн хоёр дахь ботид оруулж нийтийн хүртээл болгосон юм.

Манж, хятад, орос хэл бичгийг бага залуу насандаа бие даан сурч, эрдэм боловсролоороо нутаг усандаа гайхагдаж явсан энэ хүн Богд хаант Монгол улсын Гадаад яаманд алба хашиж, улмаар Богдын засгийн газарт доод хурлын гишүүн болж үндэсний худалдаа, мөнгө зээлийн системийг үүсгэн байгуулах, гар урлалыг

хөгжүүлж хоршооллыг өрнүүлэх, гадаадын капиталын ноёрхлыг устгах зэрэг олон асуудлаар дээд, доод хуралд санал оруулж байжээ. Ард түмний дарлал мөлжлөг, хүнд хэцүү байдлыг эсэргүүцсэн тэмцэлд идэвхтэй оролцож, бурангуй ёсыг хурцаар шүүмжлэн бичиж, шинэ дэвшилт зүйлсийг, тухайлбал морин өртөөг өөрчлөн авто машинаар шуудан хүргэдэг болох, Европын боловсон эмнэлгийг Монголд дэлгэрүүлэхийг тэр чармайж байсан байна. Б.Дорж нутгийн эрэлхэг зоригт анчид, малчин эрсийг цуглуулан зэвсэгт отряд зохион байгуулан өөрөө удирдаж дээрэм тонуул хийгч гамин цэргүүдтэй амь хайргүй тулалдаж, үлэмж хэмжээний эд хогшил, мал сүргийг дээрэмчдээс эргүүлэн авч эздэд нь өгөх буюу улсын санд тушааж байсан ажээ.

Ардын хувьсгалын дараа Гадаад яам, Сангийн яаманд ажиллаж Сангийн яамны сайдын хувиар 1924 онд хуралдсан Улсын анхдугаар их хуралд Сангийн яамны илтгэлийг тавьж хэлэлцүүлэн олон аймаг, шавиас авьяас сэргэлэн ухаантай хүмүүсийг зарлан ирүүлж сургууль байгуулан санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэхийг санал болгож байсан Бунибазарын Дорж 1925 онд "Монголд ижил нэртэй хүмүүс олширсны улмаас өндөр Гэндэн, өөхөн Гэндэн, халзан Гэндэн, халцай Гэндэн гэх зэргээр хочилж ялгах нь ихэслээ. Тиймээс хүний нэрэнд овог төрлийн нэрийг заавал хадаж хэрэглэж байх нь зүйтэй байна" гэсэн чухал саналыг Засгийн газарт оруулж, тэр ёсоор шийдвэрлэж байсан баримт ч байна.

Б.Дорж "Шинэ толь хэмээх бичиг" ба "Нийслэл хүрээний сонин бичиг"

сонинд төдийгүй, сүүлд “Харилцан туслалцах хоршооны сонин”, “Боловсон худалдаа” сонины эрхлэгчээр ажиллаж байжээ. “Шинэ толь”, “Хүмүүжил ба жигшил” сэтгүүл, “Үнэн”, “Ардын үндэсний эрх” зэрэг сонинд тэрээр олон нийтлэлээ гаргажээ. Тэр бас цөөнгүй шог хошин нийтлэл бичсэн бөгөөд “Аятайхан алба олдвоос есхөн сар”, “Зун болохгүй гэж зурхайч айлдсан”, “Алцан тагар” зэрэг шог хошин нийтлэл нь нийтэд түгсэн байна.

“Ер нь Б.Доржийн уран бүтээлд гол төлөв адгуусан амьтад гарах бөгөөд дорой буурай нь догшин зэрлэгийгээ ялан дийлж байгаагаар гардаг. Үүгээрээ нэг талаас харгис дээрэнгүйг шүүмжилж, харц ядууг өмгөөлөн хамгаалах, нөгөө талаас эрх сүрээр биш, оюун ухаанаар аливааг ялан дийлж болно гэсэн өөдрөг дэвшилт үзлийг номлосон байдаг”<sup>4</sup> гэж доктор Л.Норовсүрэн түүний нийтлэлийн онцлогийг тодорхойлсон байдаг.

“Шинэ толь хэмээх бичиг” ба “Нийслэл хүрээний сонин бичиг” сонины ажилтнуудын дотор хошой гүн Бадрахбаатар онцгой байр эзэлнэ. Тэр Харбин хотноо дорнод Хятадын төмөр замын Оросын захиргаанаас эрхлэн гаргаж байсан “Монголын сонин бичиг” сонинд “Ашиг завшаан хайж ховдог зальхай сэтгэл гарган нам нийлж үнэн замыг таглан доодсыг битүүгээр хилсдүүлэгч” (МСБ, №40), “Иргэдийг

хашраан хавчигч тэвчиж болшгүй шуналтан” (МСБ, №248), “Эрх сүрээр халхалж баатар түрэмгий явж, ядуу ардыг үл хайхран дарлагч” (МСБ, №254) зэрэг шүүмжлэлт нийтлэлийг нийтлүүлж байсан харьцангуй туршлагажсан бичигч байсан бөгөөд Хүрээн дэх “Монголын сонин бичиг” сонины

сурвалжлагчдын бүлгийг ахлан ажиллаж байжээ. Ж.Цэвээн, Д.Бодоо нар дээрх сонинд идэвхтэй бичдэг байсан байна.

Доктор Г.Дэлэг “Монголын сонин бичиг” Монгол оронд тогтмол гарах сонин хэвлэл хөгжих, сонины нийтлэх зүйлийн төрлийг олшруу-

лах, үндэсний сэтгүүлч хэвлэлийн дадлага мэргэжилтэй хүмүүсийг бэлтгэж өгөхөд тус үзүүлэв”<sup>5</sup> хэмээн тэмдэглэсэн байдаг.

Үүнээс үзэхэд хошой гүн Бадрахбаатар зэрэг монголын ирээдүйн сэтгүүлчид “Монголын сонин бичиг” сониноор дамжин дадлагажин туршлагажиж, Хүрээн дэх тэрхүү сурвалжлах бүлгийг Бадрахбаатар удирдан зохицуулж дээрх сонинтой холбож байсан нь тодорхой харагдаж байгаа бөгөөд “Шинэ толь хэмээх бичиг” сониныг Жамсраны Цэвээн үүсгэн байгуулж, анхны дугаарыг гаргахаас эхлээд Д.Бодоо, хошой гүн Бадрахбаатар зэрэг үзэг нэгт нөхөд нь хамтран зүтгэлцсэн байна.

Бадрахбаатар хэдийгээр өөрөө феодал язгууртан боловч баяд ноёд.

«

*Б.Дорж “Шинэ толь хэмээх бичиг” ба “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинд төдийгүй, сүүлд “Харилцан туслалцах хоршооны сонин”, “Боловсон худалдаа” сонины эрхлэгчээр ажиллаж байжээ. “Шинэ толь”, “Хүмүүжил ба жигшил” сэтгүүл, “Үнэн”, “Ардын үндэсний эрх” зэрэг сонинд тэрээр олон нийтлэлээ гаргажээ.*

»

лам хуварга нарын эрх мэдэл хэтэрч, тэдний дураар аашлахыг тэвчдэггүй, ховдог шунахай, үрэлгэн явдлыг нь шүүмжилж, хэмжээ хязгааргүй алба татварыг эсэргүүцдэг дэвшилт үзэлтэй сэхээтэн байсан байна. Улс орныхоо аж ахуй, эдийн засаг, соёлыг хөгжүүлэх талаар олон саналыг улсын дээд, доод хуралд оруулж, түүнийгээ хэвлэлд нийтлүүлдэг байжээ. “Шинэ толь хэмээх бичиг” ба “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинд ажиллах он жилүүдэд түүний нийтлэл улам өргөн утга агуулгатай, шүүмжлэлт өнгө аястай болж өргөжсөн байна.

“Богдын дэргэд зөвлөх эрхтэй байгуулсан, үнэн хэрэгтээ феодалын ангийн эрх ашиг, санал бодлыг илэрхийлэх үүрэг бүхий дээд, доод хурлын ажил хангалтгүй байжээ. Энэ тухай “Шинэ толь хэмээх бичиг”-ийн 1914 оны 20 дугаарт Бадрахбаатар өгүүлэлдээ “Монголын дээд, доод хоёр хурлын дотор тогтоогдсон дүрэм хэмжээ огт үгүй. Аливаа хэрэг зөвлөх хэлэлцэхэд журамгүй гэлцэнэ. Дээд хуралд 50-60 сайд ноёд цуглах боловч хэдхэн тэргүүн сайд дарангуйлан шийтгэх тул хурлын зөвлөгөөг хоосоор аваачих нь олон гэнэ. Доод хуралд 70-80 хүн цуглах боловч дарга үгүй тул нэг хэдхэн дэд түшмэл дарангуйлан шийтгэнэ гэнэ”<sup>6</sup> гэсэн байна хэмээн доктор Г.Дэлэг өөрийн номдоо тэмдэглэжээ.

“Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 ботийн хоёр дахь ботид бид хошой гүн Бадрахбаатарын “Хулгайн тухай шүүмжлэл”, “Монголын улс төрийг эвдсүгэй хэмээн залхай санаа агуулагдсдын учир”, “Оросын доод хуралд Монголын хэргийг шүүмжилсэн нь”, “Санаваас”, “Улсын хурлын газраа

өргөв” зэрэг 21 нийтлэл, захидлыг хураангуйлан оруулсан болно.

“Сэтгүүлч Бадрахбаатарын тавьж байсан санал, бичиж нийтлүүлсэн өгүүлэл нь цаг үеэ олсон, учир зүйн холбоог сайн гаргасан, аргагүй итгэгдэхээр бичсэн байдгаараа онцлог юм”<sup>7</sup> гэж доктор Г.Дэлэг өндрөөр үнэлсэн бол доктор Л.Норовсүрэн “Д.Бадрахбаатар Монголын сэтгүүл зүйн үндсийг тавьсан ууган хоёр хэвлэлд залгаагаар ажиллаж, Монголын нийтлэлийн илчлэн шүүмжлэх чиглэлийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ”<sup>8</sup> хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

**Д.** Бадрахбаатар нь амьдралын их туршлагатай, тухайн цаг үедээ өөрийн хүчин чармайлтаар бие дааж чамгүй боловсрол эзэмшсэн, дэвшилт үзэл санаатай, аливаад туйлын зарчимч хүн байжээ. Үр хүүхэддээ хатуу чанга хандаж зөв хүмүүжил олгож байсан тухай нэг биш жишээ баримт бий. Ууган хүү Цэгмид нь нүүдэл хийхээс түвэгшээн нэг удаа “Таван тэрэг хөллөдөг ч болоосой” гэж хэлэхэд нь “Гайгүй ээ, хүссэн цаг чинь ирэхээр чи таван тэрэг хөллөх болно” хэмээн хошой гүн Бадрахбаатар загнаад түүнийгээ марталгүй сүүлд хүүгээ гэрлэж өрх тусгаарлахад таван тэргэнд ачаалсан нэг гэр, цөөн тооны мал тасдан өмч болгон өгч байжээ. Тэднийх 3000-аад хоньтой, 1000 адуутай, 500-гаад үхэртэй чинээлэг баян айл байсан байна. Бага хүү Авирмэд Харбинаас сургуулиа дуусгаад ирэхэд нь зориуд иссэн хүчтэй тараг өгөөд хүү нь тамшаалахад “Чи чинь исгэлэн тараг идэж чадахгүй тамшаалах чинь, хятад болчихоо юу” гэж загнаад нуруун дундуур нь ташуурдаад авч байсан удаатай гэнэ.

Эндээс эцгийн ширүүн дүр төрх, хатуу зан байдал мэдрэгдэх боловч Бадрахбаатар нь хайраа дотроо, халаа гаднаа гаргасан гүдэс шулуухан эр хүн байсан байна. Тэр ихэс дээдэст халтай ч харц ядууст уян зөөлхөн сэтгэлээр хандаж аль болохоор тус дэм болохыг хичээдэг, хүмүүст заргын бичгийг нь хийж өгч тусалдаг хүн байжээ. Тиймээс ард олон түүнийг "Заргач Бадрахбаатар", "Болдоггүйг болгодог хүн", "Хэцүү Бадрах" гэж хүндэтгэн нэрлэдэг байсан бол ноёд түшмэдүүд "Ховын сайд", "Нохой Бадрах" хэмээн гоочилдог байсан аж. Догсомын Бодоо бол түүнд хадаг барьж орсон гарынх нь шавь байжээ.

Хамгийн сонирхолтой нь хошой гүн Бадрахбаатарынх гурван үе дамжсан сэтгүүлчидтэй юм. Хүүхдийн зохиолч, сэтгүүлч Чойлонгийн Лувсандэндэв, түүний дүү Чойлонгийн Тогоонтөмөр нар бол Бадрахбаатарын гал зээ нар нь болох бөгөөд Ч.Тогоонтөмөрийн төрсөн охин Наранмандухай нь үндэсний мэдэллийн МОНЦАМЭ агентлагт сэтгүүлчийн мэргэжлээр ажиллаж байна.

**М**онголын анхны тогтмол хэвлэл "Шинэ толь хэмээх бичиг" ба "Нийслэл хүрээний сонин бичиг" сонинд Ж.Цэвээнтэй хамтран зүтгэж байсан хүмүүсээс харьцангуй илүү мэдээлэл олдсон нь хошой гүн Бадрахбаатар болно. Бусдынх нь үр хүүхэд, залгамжлагчаас олж уулзсан хүн одоогоор алга. Автономитын шүүх Яамны бага түшмэл Жанцансамбуу "Шинэ толь хэмээх бичиг"-т шуурхай мэдээ мэдээллийг хариуцдаг байсан гэсэн мэдээлэл байдаг ч илүү дэлгэрэнгүй мэдээлэл олдоогүй байна.

Ерэн онд Монголд ардчилсан хувьсгал ялж, өнгөрсөн түүхээ үнэн зөвөөр шүүн тунгаах бодит бололцоо бүрэлдсэнээр их соён гэгээрүүлэгч Ж.Цэвээн, анхны сэтгүүлч-анхны ерөнхий сайд Д.Бодоо зэрэг дэвшилт сэхээтнүүдэд хандах хандлага өөрчлөгдөж, тэдний бүтээл туурвилыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нээн үзүүлэх боломж буй болсон нь ардчиллын нэг чухал ололт гэж үзэх учиртай. Тийм учраас "Жамсраны Цэвээн судлал"-ыг цаашид улам чанаржуулан өргөжүүлэхдээ "Шинэ толь хэмээх бичиг" ба "Нийслэл хүрээний сонин бичиг" сонинд түүнтэй хамтран зүтгэж байсан бусад хүн — Бодоо, Бадрахбаатар, Дорж, Жанцансамбуу зэрэг нийтлэлчдийн үйл ажиллагаатай нягт уялдуулж холбон авч үзэж судлах нь дээрх сонинуудын үйл ажиллагаа, нийтлэлийн чиглэлийг зөв ойлгож ухаарах, илүү өргөн хүрээнд задалж шинжлэхэд тус нэмэртэй гэж бодож байна.

"Шинэ толь хэмээх бичиг" ба "Нийслэл хүрээний сонин бичиг" сонин нь зөвхөн анхдагч хэвлэл болон төрж мэндэлсэнээрээ Монголын тогтмол хэвлэлийн түүхэнд бичигдэн үлдэх төдийгүй Монголд чөлөөт ардчилсан хэвлэлийн эхлэлийг тавьснаараа, хувийн хэвшлийн анхны сонин дүр төрхийг тодорхойлж буй болгосноороо онцгой ач холбогдолтой юм гэдгийг илтгэлийнхээ эцэст ахин нэгэнтээ сануулан тэмдэглэж хэлэхэд илүүдэхгүй гэж бодож байна.

#### Ишлэл

<sup>1</sup> 1977. Жамсраны Цэвээн. Түүвэр зохиолууд. УБ., 12 дахь тал.

<sup>2</sup> 2011. Монголын шилдэг нийтлэл. УБ., 5 дахь тал.

<sup>3</sup> Магсаржав Н. 1994. Монгол Улсын шинэ түүх // Гар бичмэл эхээс кирилл бичгээр хэвлүүлсэн О.Батсайхан, З.Лонжид. УБ.

<sup>4</sup> 2011. Монголын шилдэг нийтлэл. УБ., 97 дахь тал.

<sup>5</sup> Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 68 дахь тал.

<sup>6</sup> Дэлэг Г. Дурд зох., 70-71 дэх тал.

<sup>7</sup> Дэлэг Г. Дурд зох., 145 дахь тал.

<sup>8</sup> Норовсүрэн Л. 2011. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ., 166 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ.

2. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.

3. 2011. Их соён гэгээрүүлэгч Жамсраны Цэвээн (1880-1942). (Эмх. Ч.Нарантуяа). УБ.

4. Норовсүрэн Л. 2011. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

5. Норовсүрэн Л. 2012. XX зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид. УБ.

6. 1993. Цагаан ном. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн судалгааны төв. I боть. УБ.

7. Цэвээн Ж. 1997. Түүвэр зохиолууд. I эмхтгэл. УБ.

8. Цэвээн Ж. 2000. Түүвэр зохиолууд. II эмхтгэл. УБ.

9. Цэцэгмаа Ж. Ц.Жамцарано — основатель образовательных учреждений в Монголии // Мир Центральной Азии. Материалы междунар. науч. конф. Улан-Удэ, 2002. Т. II. История. Социология.

### Резюме

В настоящей статье автор предпринял попытку установления авторства публикаций, вышедших в первых отечественных газетах — “Шинэ толь хэмээх бичиг” и “Нийслэл хурээний сонин бичиг”. Серьезную трудность представляет тот факт, что авторы газетных выступлений использовали в большинстве случаев псевдонимы. Главными соратниками Ж.Цэвээнэ, главного редактора вышеупомянутых газет, являлись Догсомын Бодоо, в будущем известный политик, граф Бадрахбаатар, Бунибазарын Дорж, Жанцансамбуу и др., оказавшие большое влияние на развитие монгольской журналистики.